



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2024.07.29 № 691
танай -ны № -т

Г ХЭНТИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ДАДАЛ СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНД

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Дадал сумын Монгол ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай

232420718

хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.


Дүгнэлт

Дадал сумын Монгол ардын намын хорооны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Дадал сумын Монгол ардын намын хорооны мөрийн хөтөлбөр (10 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хэнтий аймгийн Дадал сумын Сонгуулийн хороонд.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ж.ГАНБААТАР

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР  Д.ОЮУНТУЯА

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР  Ц.БИЛЭГСАЙХАН

АУДИТОР  Ц.ХАТАНБОЛД

ХЭНТИЙ АЙМГИЙН ДАДАЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024
ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Агуулга

НЭГ. ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРД ХҮРГЭХ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 1.1. Эрүүл мэнд
- 1.2. Боловсрол
- 1.3. Орон сууц
- 1.4. Хөдөлмөр эрхлэлт, ажлын байр, тогтмол орлого
- 1.5. Соёл, урлаг, спорт
- 1.6. Нийгмийн бүлэг

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО

- 2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт 2017141297
СЮЛ 047/0071/52
- 2.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
- 2.3. Төсөл хөтөлбөр, хамтын ажиллагаа
- 2.4. Орон нутгийн орлого

**ГУРАВ. ШУДАРГА ЁС - ИРГЭДИЙН ОРОЛЦОО, ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН
БОДЛОГО**

- 3.1. Нутгийн өөрөө удирдах ёсны хяналт
- 3.2. Төрийн алба, хүний нөөц
- 3.3. Хамтын оролцоотой иргэд
- 3.4. Гэмт хэрэг, зөрчил, гамшгаас урьдчилан сэргийлэх асуудал
- 3.5. Хил хамгаалалт
- 3.6. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

ДӨРӨВ. ЭРҮҮЛ ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГО

- 4.1. Эрүүл хүнс - өрхийн үйлдвэрлэл
- 4.2. Газар тариалан
- 4.3. “Шинэ хоршоо” хөдөлгөөн



4.4. “Дадал ухаа” үүлдэр, эрүүл бүс

4.5. Хадлан бэлчээрийн менежмент

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО

5.1. “Тэрбум мод” хөдөлгөөн

5.2. Тусгай хамгаалалттай газар

5.3. Байгалийн нөөцийн хамтын менежмент

5.4. Түүхийн дурсгалт газар, соёлын биет өвийн хамгаалалт

5.5 Газрын харилцаа

5.6. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ

5.7. Орон нутгийн звент

ЗУРГАА. БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛД СУМЫН ОРОЛЦОО

СҮРДЭНЭКИЙН



НЭГ. ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРД ХҮРГЭХ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1. Эрүүл мэнд

- 1.1.1. “Элэг бүтэн-Монгол”, “Хүүхдийн эрүүл шүд”, “Умайн хүзүүн хавдаргүй-Монгол” хөтөлбөрүүдийг орон нутагт хэрэгжүүлнэ.
- 1.1.2. Аюултай хог хаягдлыг устгах стандартын зуухтай болгоно.
- 1.1.3. Сумын Эрүүл мэндийн төвийн албан хаагчдын ажиллах орчныг сайжруулан, шаардлагатай орон тоогоор хангана.
- 1.1.4. Багийн эмч нарыг баг дээрээ ажиллах нөхцөл бололцоогоор хангаж, унаажуулах ажлыг зохион байгуулна.
- 1.1.5. Иргэдийг эрт илрүүлэгт хамрагдалтын хувийг өсгөнө.
- 1.1.6. Урьдчилан сэргийлэх үзлэгийг улиралд 1 удаа зохион байгуулж, халдварт бус өвчлөлийг бууруулна.
- 1.1.7. Зонхилон тохиолдох өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулна.
- 1.1.8. Эрүүл мэндийн төвийн түргэний машиныг шинэчлэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.2. Боловсрол

- 1.2.1. Ерөнхий боловсролын сургуулийг багшлах мэргэжлийн боловсон хүчинээр 100 хувь хангана.
- 1.2.2. Хилийн заставын шинээр байгуулагдсан сургуулийн өмнөх боловсролын салбарыг дэмжин ажиллаж цэцэрлэгийн насын хүүхдийг цэцэрлэгт 100 хувь хамруулна.
- 1.2.3. Ерөнхий боловсролын хүний нөөцийг бүрдүүлэх, дутагдалтай мэргэжлээр суралцаж буй оюутан, хөрвөн суралцах багшийг бодлогоор дэмжин ажиллана.
- 1.2.4. Бага дунд боловсролын чанарыг дээшлүүлж сургалтын хөтөлбөр агуулга арга зүйд буриад хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний хөгжил, төлөвшил, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийг тусган хэрэгжүүлж хүүхдийн өөрийнх нь авьяаст тулгуурлан хүүхдийг хөгжүүлж, амьдралын зөв дадалд сургана.
- 1.2.5. Нүүдлийн соёлын чадавхыг ерөнхий боловсролын сургалтаар өгөх, бэхжүүлэх хүрээнд биеийн тамирын хичээлийн агуулгад үндэсний бөх, технологийн хичээлд хатгамал, дээл оёх, хөгжмийн хичээлд уртын дуу, морин хуур, биелгээг оруулна.
- 1.2.6. Сумын Ерөнхий Боловсролын Сургуулийн хичээлийн байрны барилгын өргөтгөлийг барьж байгуулна.



1.3. Орон сууц

- 1.3.1. Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлж буй ипотекийн зээлд нутгийн иргэдийг хамруулах бодлогыг баримталаа.
- 1.3.2. Орчин үеийн ариун цэврийн байгууламж бүхий Хаус орон сууцыг сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн хувийн хэвшилтэй хамтран барьж байгуулан ашиглалтад оруулна.
- 1.3.3. Инженерийн шугам сүлжээнд холбогдсон 16 айлын орон сууцыг сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн барьж ашиглалтад оруулна.
- 1.3.4. Сум орон нутагт нэн шаардлагатай боловсон хүчнийг түрээсийн орон сууцаар хангаж өмчлүүлэх арга хэмжээг авч ажиллана.

1.4. Хөдөлмөр эрхлэлт, ажлын байр, тогтмол орлого

- 1.4.1. Түр болон байнгын ажлын байраар хангах замаар иргэдийн өрхийн орлогыг нэмэгдүүлж, амьжиргааны түвшинг дээшлүүлнэ.
- 1.4.2. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлнэ.
- 1.4.3. Жижиг, дунд гарааны бизнес эрхлэгчдийг зээлийн бодлогоор дэмжиж хамтран ажиллана.
- 1.4.4. Залуу малчдыг малжуулах төсөлд хамруулж хамтран ажиллана.
- 1.4.5. Ахуй үйлчилгээний төвийг байнгын ажиллагаатай болгоно.

1.5. Соёл, урлаг, спорт

- 1.5.1. Хүүхэд залуучуудын авьяасыг нээн, хөгжүүлэх секц дугуйлангийн тоог нэмэгдүүлэн тогтмол ажиллуулах.
- 1.5.2. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлж бие бялдрын өв тэгш хүмүүжлийг олгоно.
- 1.5.3. Сум орон нутагтаа аймаг бус болон улсын чанартай тэмцээнийг зохион байгуулна.
- 1.5.4. Биет болон биет бус өв соёлыг иргэдэд түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна.
- 1.5.5. Хөнгөн атлетик болон өвлийн спортыг орон нутагт хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллана.



1.6. Нийгмийн бүлэг

- 1.6.1. Төрийн ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааны хөтөлбөр боловсруулж бодитой үнэлэх, үнэлэмжийг нэмэгдүүлэх зорилгоор төсөл арга хэмжээг иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.
- 1.6.2. Залуучууд, ахмадуудын хөгжлийн төвийг байнгын ажиллагаатай болгож үйл ажиллагааг нь дэмжинэ.
- 1.6.3. Тусгай хэрэгцээ шаардлагатай иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэн хамтран ажиллана.

1.6.4. Үндэсний өв соёл, урлаг спортын төрлүүдийг хөгжүүлж хамтран ажиллана.

1.6.5. Иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх талбайг сумын төвийн гэр хорооллууд дунд нэмж байгуулна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт

- 2.1.1. Норовлин-Дадал чиглэлийн хатуу хучилттай зам барьж ашиглалтад оруулах талаар холбогдох газарт уламжлан шийдвэрлүүлж хамтран ажиллана.
- 2.1.2. Балж голын төмөр бетонон гүүрийг барьж ашиглалтад оруулах талаар холбогдох газарт уламжлан шийдвэрлүүлнэ.
- 2.1.3. Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байрны барилгын өргөтгөл барих ажлыг холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 2.1.4. Хүүхэд залуучуудын соёл амралтын хүрээлэнг барьж байгуулахад холбогдох газарт уламжлан шийдвэрлүүлж хамтран ажиллана.
- 2.1.5. Дэлүүн Болдог нисэх онгоцны буудлаас сумын төв хүртэл 8 км хатуу хучилттай замыг барих төслийг хамтран хэрэгжүүлнэ.

2.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

- 2.2.1. Хөрхон голд төмөр тулгууртай модон гүүрийг барьж ашиглалтад оруулна.
- 2.2.2. Төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд ойр байрлах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, нийтийн орон сууцуудыг шат дараатайгаар холбоно.
- 2.2.3. Шинэ суурьшлын бүсэд амьдарч байгаа айл өрхүүдийг цахилгаан эрчим хүчээр шат дараатайгаар хангана.



2.2.4. Сумын төвд инженерийн шугам сүлжээнд холбогдсон нийтийн халуун ус, ариун цэврийн байгууламжийг барьж ашиглалтад оруулна.

2.2.5. Өрхийн үйлдвэрлэл, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор дотоод, гадаадын жуулчдад зориулсан худалдааны нэгдсэн төвтэй болно.

2.3. Төсөл хөтөлбөр, хамтын ажиллагаа

2.3.1. Чингис хаан аялал жуулчлалын цогцолборын бүтээн байгуулалтын хүрээнд аялал жуулчлалын мэдээллийн жишиг төв, Хажуу булаг, Дэлүүн болдог, Эрчижт овооны тохижилтын ажлыг дуусгаж ашиглалтад оруулна.

2.3.2. Бөөр булгаас Хажуу булаг хүртэлх аялагч, жуулчдын аялах нөхцөл боломжийг бүрдүүлсэн замыг барьж ашиглалтад оруулна.

2.4. Орон нутгийн орлого

2.4.1. Сумын орлогыг тодорхой хувиар өсгөж ажлын байрыг нэмэгдүүлнэ.

2.4.2. Малын тоо толгойн албан татварын зарцуулалтыг ил тод болгож малчдад тайлагнадаг үйл ажиллагааг сайжруулна.

ГУРАВ. ШУДАРГА ЁС - ИРГЭДИЙН ОРОЛЦОО, ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

3.1. Нутгийн өөрөө удирдах ёсны хяналт

3.1.1. Нийгмийн бодлого, байгаль орчин аялал жуулчлал, төсөв санхүү дэд бүтэц, сахилга хариуцлага дэг журам, хүнс хөдөө аж ахуй, төрийн байгуулалтын хяналт эрх зүйн хороодоор дамжуулан иргэдийн эрх ашигт нийцсэн хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

3.2. Төрийн алба, хүний нөөц

3.2.1. Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, залуу боловсон хүчнийг сум орон нутагтаа ажиллах нөхцөл боломжоор хангана.

3.3. Хамтын орлцоотой иргэд

3.3.1. Төрийн үйл ажиллагаанд иргэдийн орлцоог нэмэгдүүлэн хамтран ажиллана.

3.3.2. Иргэдэд ойр, ил тод нээлттэй төрийн үйлчилгээг үзүүлнэ.

3.4. Гэмт хэрэг, зөрчил, гамшгаас урьдчилан сэргийлэх асуудал



3.4.1. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.5. Хил хамгаалалт

3.5.1. Хилчин албан хаагчдыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган ажиллана.

3.6. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

3.6.1. Зүүн бүсийн хил дагуух сум, тосгодтой хамтын ажиллагааг сайжруулан ажиллана.

ДӨРӨВ. ЭРҮҮЛ ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГО

4.1. Эрүүл хүнс - өрхийн үйлдвэрлэл

4.1.1. Хүлэмжийн аж ахуйг дэмжиж, эрүүл хүнсний ногоогоор хангах бодлого баримтлан хамтран ажиллана.

4.1.2. Өрх бүр өрхийн хэрэгцээнд төмс, хүнсний ногоо тариалахад дэмжлэг үзүүлнэ.

4.1.3. 30-100 тонны багтаамжтай стандартын шаардлага хангасан төмс, хүнсний ногоо хадгалах зоорь барихад бодлогоор дэмжинэ.

4.1.4. Туслах аж ахуйг хөгжүүлэн бодлогоор дэмжин хамтран ажиллана.

4.1.5. Max, сүү, сүүн бүтээгдэхүүн байгалийн дагалдах баялаг, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоог нэмэгдүүлж өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогыг баримтлан ажиллана.

4.2. Газар тариалан

4.2.1 Эргэлтэд байгаа газар тариалангийн газрыг бүрэн хашаажуулж малчид, аж ахуйн нэгжүүдийн маргааныг гуравласан гэрээгээр зохицуулна.

4.2.2. Малчид, хоршоодыг ногоог тэжээл, овьёос тариалахад бодлогоор дэмжин хамтран ажиллана.

4.3. “Шинэ хоршоо” хөдөлгөөн

4.3.1. Хоршоодын үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллана.



4.4. “Дадал ухаа” үүлдэр, эрүүл бүс

- 4.4.1. Эрүүл бүсийн журмыг батлуулан хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.
- 4.4.2. Дадал ухаа үүлдрийн генийн санг хамгаалах бодлого баримтална.
- 4.4.3. Малын эрүүл мэндийг хамгаалах цогц арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.

4.5. Хадлан бэлчээрийн менежмент

- 4.5.1. Бэлчээр ашиглах журмын хэрэгжилтийг ханггуулж ажиллана.

- 4.5.2. Бэлчээрийг усжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлнэ.

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО

5.1. “Тэрбум мод” хөдөлгөөн

- 5.1.1 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд төлөвлөгөөт модыг тарьж ургуулна.

- 5.1.2 Өрх бүр хашаандaa жимс, жимсгэний мод тарьж өрхийн хэрэглээгээ хангах нөхцөл бололцоог дэмжин уриалга гарган ажиллана.

5.2. Тусгай хамгаалалттай газар

- 5.2.1 Орон нутгийн хамгаалалттай газрын менежментийг сайжруулж төсөл хөтөлбөртэй хамтран ажиллана.

- 5.2.2 Онон-Балжийн байгалийн цогцолборт газрын орчны бүсийн менежментийн төлөвлөгөө, орчны бүсийн сан, зөвлөлийн болон хамтын үйл ажиллагааг сайжруулна.

- 5.2.3 Онон-Балжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай хамтран тусгай хамгаалалттай газрын тухай хуульд нийцүүлэн газар ашиглалтыг менежментийн төлөвлөгөөнд нийцүүлэн хэрэгжүүлнэ.

5.3. Байгалийн нөөцийн хамтын менежмент

- 5.3.1 Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүдийг малчдын бүлэг, аравтын зохион байгуулалтад нийцүүлэн байгуулж хамтран ажиллана.

- 5.3.2 Ан амьтан, загас агнуурын бүс нутгуудын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж жишиг бүс болгоно.



5.4. Түүхийн дурсгалт газар, соёлын биет өвийн хамгаалалт

5.4.1. Биет болон биет бус өвийг хамгаалан аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ болгоход бодлогоор дэмжин ажиллана.

5.5 Газрын харилцаа

5.5.1 Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулан хэрэгжилтийг хангана.

5.5.2 Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2020-2035 бодлогын баримт бичигт тодотгол хийж ажиллана.

5.5.3 Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг сумын хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан батлуулж хэрэгжилтийг хангуулан ажиллана.

5.6. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ

5.6.1. Малчдын хотонд аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлж өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд бодлогоор дэмжин хамтран ажиллана.

5.6.2. Дотоод, гадаадын жуулчдыг хүлээн авах стандартын шаардлага нийцсэн зочид буудал, жуулчны бааз, гэр буудал барьж байгуулах санаачилгыг дэмжинэ.

5.6.3. Зочлох үйлчилгээ, хөтөч тайлбарлагч, гадаад хэлний мэдлэг чадвар олгох сургалт, аялал жуулчлалын зөвлөгөөнийг тогтмол явуулж өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

5.6.4. Эко гэр, отоглох хоноглох цэг байгуулж ажиллах иргэдийг дэмжиж хамтран ажиллана.

5.6.5. Аялал жуулчлалын нэгдсэн мэдээллийг сайжруулна.

5.7. Орон нутгийн эвент


5.7.1. Балжийн андууд мөсөн шагайн олон төрөлт тэмцээн, Монгол бахархлын өдөр Мялаагуудын хурим, Тулын өдөрлөг зэрэг арга хэмжээг орон нутгийн эвент болгоно.

5.7.2. Улсын болон аймаг бүсийн чанартай эвент арга хэмжээнүүдийн туршлага судалж орон нутагт хэрэгжүүлж орох орлогыг нэмэгдүүлнэ.



ЗУРГАА. БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛД СУМЫН ОРОЛЦОО

- 6.1. "Нээлттэй сум" дэд хөтөлбөр
- 6.2. "Төрөлх нутагтаа бид" дэд хөтөлбөр
- 6.3. "Авъяастай Дадалчууд" дэд хөтөлбөр
- 6.4. "Эрүүл, оюунлаг Дадалчууд" дэд хөтөлбөр
- 6.5. "Бизнес–хөрөнгө оруулалт" дэд хөтөлбөр
- 6.6. "Хоггүй Дадал" дэд хөтөлбөр
- 6.7. "Баталгаатай төрийн албан хаагч" дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.



Мэдээллийг бэлтгэсэн Хамсийн амьтны Дугал Сүнзүү МАНын хороо -ыг төлөөлж
Нам/эвслийн/нэр

(тэмдэг) Мурзин -ыг төлөөлж
албан тушаал
Дашнүүрэв Монгол
овог нэр
гарын үсэг
(тэмдэг) Мурзин -ыг төлөөлж
албан тушаал
овог нэр
гарын үсэг

2024 оны 07. сарын 23. өдөр